


# Ажилчид ойчих, эд зүйлс унах болон тээврийн хэрэгслээс үүдэх осол гэмтэл

16


Багаж хэрэгсэл эсвэл дээрээс унасан юманд цохиулахыг хүмүүс ихэвчлэн “Тэр осолд орчихлоо” гэж хэлдэг. Харин ажилчин өндрөөс ойчих болон шалан дээр бүдэрч унахад, түүнийг анхаарал болгоомжгүй эсвэл эв хавгүй гэж буруутгадаг. Хэрвээ ажилчны хөл гар дээгүүр өргөх машин гарах юм бол жолооч ч, ажилчин ч хоёулаа хаашаа явж байгаагаа хараач гэж хэлцгээдэг. Гэвч эдгээр “осол” нь ажилчдын буруу биш юм. Үйлдвэр нь ажилчдад аюулгүй байдлаар цэвэр шал, аюулгүй зам, агуулахыг загварчлан тохижуулсан байх ёстой. Ажилчдад тухайн ажлын байрыг аюулгүй байлгах багаж хэрэгсэл, цаг хугацааг өгч байх хэрэгтэй.



Ажилчин унах үед хэнийг буруутгах вэ?

## Өндөөс ойчихоос сэргийлэх


Шалнаас дээш өндөрт ажиллахдаа өндөөс ойчих, багаж тоног төхөөрөмж болон эд зүйлс доор байгаа ажлын талбай руу унахаас сэргийлэх хамгийн сайн арга нь тэнцвэртэй тавцан дээр ажиллах явдал юм. Энэ тавцан нь хөдөлгөх боломжтой эсвэл нэг байранд угсарч бэлдсэн байж болдог. Тавцан нь ажилтан ажлаа хийхэд хангалттай хэмжээний талбайтай байх ёстой ба багаж хэрэгсэл, материалаа тавих зайдай байх хэрэгтэй.



## Эд зүйлс унааж гэмтээхээс сэргийлэх

Багаж хэрэгсэл эсвэл эд зүйлс дээрээс унасаар ажилчид ноцтой гэмтэл авч, амь насаа ч алдаж болно. Дээрээс юм унахаас сэргийлэхийн тулд дараах зүйлсийг хий:

- Дээгүүр явж буй краны рельс, тавцан эсвэл бараа хадгалах хэсгийн тушаа доор нь ажлын талбар, явах замыг байршуулж болохгүй.
- Бараа материал, савыг хэт өндөрт болон тэгш бус өрөхгүй байх. Тавиур дээр өрөх дээд хэмжээг тэмдэглэ.
- Тавцан, өндөрлөгдсөн агуулах хэсгийн тавцанг бараа материалыг дааж чадахуйцаар шалнаас бэхлэгдсэн байлга. Даацын хязгаарын дагуу юмсыг байрлуул.
- Өндөр тавцан дээр ачих, буулгах ажлын үед түүний доор хүн байж болохгүй.
- Өргөгч механизмын жолооч нь ачих, буулгах, өргөх үйл ажиллагааг аюулгүй хийх сургалтад хамрагдсан байна.
- Машин нь ачаа унах үед жолоочийг хамгаалахаар тоноглогдсон байх.




- Өндөрт өргөгдсөн ажлын талбарт байгаа ажилчид хамгаалалтын дуулга өмссөн байх. Хамгаалалтын дуулга нь эд зүйлс унаж толгойг ноцтой гэмтэхээс хамгаалах ч овор ихтэй том эд зүйлс унахаас хамгаалж чадахгүй. Энэ нь хузүү болон бие гэмтэхээс хамгаалахгүй юм.

## Халтирч, бүдэрч, тээглэж унахаас сэргийлэх

Овон товонтой шал, шалны нүх, шалны өндөр намын өөрчлөлт, нойтон шал, утас, шалан дээрх хог хаягдал зэрэг нь ажилчид халтирч, бүдэрч, тээглэж унах шалтгаан юм.

Дараах аргаар унахаас урьдчилан сэргийлж болно:

- Барзгар шалыг засах;
- Явах замыг цэвэрхэн байлгах;
- Шалны түвшин өөрчлөгдхөх, шат, налуу хэсэг гэдгийг нь тэмдэглэж бүрснээр та тэдгээрийг харах болно;



**Тээглэх, халтирах, унахаас ихэвчлэн урьдчилан сэргийлж болдог.**

- Тос, химиийн бодис асгарсан бол нэн даруй цэвэрлэх;
- Хог хаягдал, шороо тоосыг тогтмол цэвэрлэх;
- Сул утсыг шал эсвэл ханан дээр скочоор дарж наах;
- Илүү тод, олон гэрэлтүүлэг нэмэх;
- Халтиргаанаас хамгаалах гутал өмсөх.

## **Машин механизмын гэмтлээс сэргийлэх**


Зарим аюул нь үйлдвэрийн дотор болон гадна байх моторт машин механизмаас болдог. Моторт машин механизмаас үүсэх гэмтлийг зам, үйлдвэрийн бус дэх машин механизм болон явган хүний явах замыг салгаж тэмдэглэснээр урьдчилан сэргийлж чадна. Машин механизм нь тогтмол засвар үйлчилгээ хийгдсэн байх ёстой ба ажилчид нь аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байвал зохино.

Дотор мотор ажиллах үед түлш шатаж, ажилчид шатсан түлш эсвэл бензиний аюултай утаагаар амьсгалдаг. Пропанаар ажилладаг машин механизм нь илүү аюул багатай ч цахилгаан машин механизм нь түлш шатаадаггүй тул хамгийн аюулгүй нь юм.

Ажилчдыг машин механизмаас хамгаалахдаа:

- Машин механизмын замаас явган хүний замыг ялгаж замын шугамыг тэмдэглэх;
- Машин механизмын зам явган замтай огтлолцох хэсэгт хурдны хязгаар болон “зогс” тэмдэг байрлуул;
- Явган хүний замыг ашиглаж байгаа хүний тоонд тохируулан хангалттай өргөн байлга;
- Машин механизмд эргэх, явах хөдөлгөөн хийхэд бусад машин, багаж, материал болон машин механизм эсвэл хүнтэй мөргөлдөхөөргүй зайд үлдээ;
- Зогсоолд байрлуулсан машин механизм, хадгалж буй хангамж болон хогийг явган замаас чөлөөлж, цэвэрлэх;
- Машин механизмыг шугам эсвэл явган замыг хаахааргүй газар зогсоолд байрлуул;
- Бараа материалыг байрлуулахдаа жолооч болон явган хүмүүс бие биенээ чөлөөтэй харахаар байрлуулж хадгал;
- Жолооч нарыг жолоодох, хэрхэн ачиж буулгах аюулгүй ажиллагаанд сурга;

- Машин механизмд тогтмол засвар үйлчилгээ хий.



### **Ажилчин нас барсны дараа л үйлдвэр зогсоолоо сайжруулсан юм**

Силвия Мексикийн Солэлектронд ажилладаг байв. Тэр өдөр бүр үйлдвэртээ очихын тулд ачааны жижиг машинд суудаг байв. Нэг өглөө тэр буусныхаа дараа хаалга чиглээд алхаж байх үед ажилчдыг суулгасан жижиг ачааны машин түүнийг мөргөж, хөл дээгүүр нь гарчээ.

Найзууд болон машины жолооч нь түүнд туслахыг оролдсон юм. Нэг нь үйлдвэрийн сувилагчийг авчрахаар гүйв. Гэвч сувилагч тэнд эргэлзсэн байдалтай зүгээр л зогсоод байв. Хэдий тэр хөдөлж болохгүй ч Силвиаг түрдэг тэргэнцэр дээр суулгахыг хүсэв. Эцсийн эцэст хэн нэгэн нь дамнуурга авчирлаа. Тэд Силвиаг жижиг ачааны машинд суулгаж маш хурдан эмнэлэг рүү давхив.

Мэс заслын дараа Силвия маш ноцтой халдварт авсан байв. Гэвч хэн ч, тэр дундаа тээвэрлэлт хийсэн машиныг эзэмшидэг Солэлектрон хүргтэл түүний гэмтэл, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг хариуцахыг хүсээгүй юм. Тиймээс эмнэлэг түүнийг эмчлэхээс татгалзав. Эмчилгээгүйгээр түүний

халдварт хүндэрэв.

Түүний гэр бүлийнхэн Мексикийн хөдөлмөрийн байгууллагын CEREAL-ын хуульчтай холбогджээ. Тэд тээвэрлэгч байгууллагаар даатгалыг нь төлүүлэхийг хичээсэн ч энэ нь хэтэрхий оройтсон байв. Сильвия бүрэн эмчлэх боломжтой халдвараас болж хэд хоногийн дараа нас барсан юм.

Түүний үхлийн дараа CEREAL-ын хуульч, тээвэрлэгч компани Солэлектрон Сильвиагийн гэр бүлийнхэнтэй уулзжээ. Аль аль компани нь нас барсан ажилтанд өгөх хуульд заасан дээд хэмжээний нөхөн олговрыг төлөхөөр зөвшөөрсөн юм. Энэ нь компаниуд дандаа сүүлд нь хариуцлагаа хүлээдгийн нэг жишээ юм. Ургэлж хожимдсон байдал.

Гэвч асуулт хэвээрээ үлдсэн юм: Яагаад ийм юм болов? Олон ажилчид тээврийн машин болон Солэлектроны авто зогсоолын талаар гомдол гаргасан юм. Тэнд ямар нэг систем гэхээр юм байсангүй. Өөр компаниудаас ирсэн машинууд ямар ч тэмдэг, явган гарц байхгүйгээр ирээд л явдаг байв. Тэд авто зогсоолд илүү олон хүн буулгахаар уралдан өрсөлддөг байсан тул ажилчид тэднээс бултхааас өөр аргагүй байдаг байв. Солэлектрон тээврийн компанийг Сильвиагийн үхэлд буруутай, хариуцлага хүлээ гэж тэмцэж байх үест үйлдвэрийн авто зогсоол өөрчлөгдж байв. Тэд жолооч болон алхаж яваа хүмүүст илүү сайн аюулгүй байдлыг мэдрэхэд нь тус болох гэрэлтүүлэг байрлуулав. Тэд машины хурд сааруулагч, шулуун замын тэмдэглэгээ байрлуулав. Одоо тэнд аюулгүй алхах зам бий бөгөөд мөн үйлдвэрийн ажилчдыг буулгах бүстэй болжээ.

Сильвия болон бусад олон ажилчны амь нас, гэмтэл бэртлээр буюу өндөр үнээр эдгээр өөрчлөлтөд хүрсэн билээ.